



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/70

Халбан

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 103 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэцэрлэг сумын Орон нутгийн хөгжлийн сангаар санхүүжигдэх 70,000,000 (далан сая) төгрөгний өртөгтэй “Тусгай зориулалтын трактор худалдаж авах” ажлын гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: М.Ренчиндорж (Засаг даргын Тамгын газрын нярав)

Гишүүд: Н.Ганжуур (Татварын Улсын Байцаагч)

Т.Оюунсайхан (Иргэний төлөөлөл)

Ч.Бямбасүрэн (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: С.Долгоржав (Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын багш)


2.Худалдан авах ажиллагааг хууль, журам, батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (М.Ренчиндорж)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Бямбажав)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.АНХБАЯР

БАТЛАВ  
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА  Н.АНХБАЯР

УНИВЕРСАЛ ТРАКТОР

Техникийн тодорхойлолт

|                                      |                    |
|--------------------------------------|--------------------|
| Техникийн загвар                     | NM-E60             |
| Хөдөлгүүрийн загвар                  | YUNNEI490          |
| Хэмжээ, мм                           | 5200*1800*2650     |
| Нийт жин, кг                         | 4100               |
| Хөдөлгүүрийн хүч, кВт                | 37, HP50           |
| Хөдөлгүүрийн эргэлтийн хурд, эрг/мин | 2400               |
| Гидралвик системийн даралт, мПа      | 16                 |
| Тэнхлэг хоорондын зай, мм            | 1400               |
| Хурд, км/цаг                         | 25                 |
| Түлшний сав, L                       | 45                 |
| Гидравлик сав, L                     | 45                 |
| Жолооны төрөл                        | 4 дугуй хөтлөгчтэй |
| Дугуй                                | 20,5/70-60         |
| Экскаватор тоног                     |                    |
| Шанагны өргөн, мм                    | 420                |
| Шанагны эзэлхүүн, м <sup>3</sup>     | 0,05               |
| Хамгийн их ухах өндөр, мм            | 3400               |
| Буулгах өндөр, мм                    | 2000               |
| Малталын гүн хэмжээ ихдээ, мм        | 2000               |
| Эргэлтийн өнцөг,                     | 180                |
| Ковш тоног                           |                    |
| Хамгийн их буулгах өндөр, мм         | 2900               |
| Хамгийн их өргөх өндөр, мм           | 3950               |
| Шанагны өргөн                        | 1800               |
| Шанагны эзэлхүүн м <sup>3</sup>      | 0,9                |

АЖЛЫН ДААЛГАВАР БОЛОВСРУУЛСАН:  
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  Д.ОТГОНБАЯР